

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/23/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН 2022
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70273465 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БШУ	Боловсрол шинжлэх ухааны

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.08.16 № 01/56
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН
ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.НАРАНТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь боловсролын салбарт аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан "Хүүхэд бүр цэцэрлэгт", "Хөгжсөн багшаас чадварлаг суралцагч", "Хүүхдийн хүмүүжил төлөвшлийг сайжруулах", "Хүүхдэд ээлтэй дотуур байр" дэд хөтөлбөрүүдийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж хүүхдийн хүмүүжил төлөвшлийг сайжруулж, тэдний амьдрах суралцах таатай орчныг бүрдүүлэх, багшийг чадавхжуулах зорилт тавин үр дүнг тооцон ажилласан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,175,640.24	44,073,478.71
33	АВЛАГА	23,644,500.00	0
33500	Бусад авлага	23,644,500.00	0
33510	Байгууллагаас авах авлага	23,644,500.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	12,870,150.00	14,727,299.00
35400	Хангамжийн материал	12,870,150.00	14,727,299.00
35410	Бичиг хэргийн материал	504,400.00	245,000.00
35420	Аж ахуйн материал	10,727,150.00	11,424,699.00
35440	Түлш, шатах тослох материал	790,000.00	2,760,000.00
35470	Бусад хангамжийн материал	848,600.00	297,600.00
36	НӨӨЦИЙН БАРАА	5,660,990.24	29,346,179.71
36100	Барааны нөөц	5,660,990.24	29,346,179.71
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	538,652,363.73	575,685,855.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	538,652,363.73	575,685,855.95
39200	Биет хөрөнгө	522,477,535.39	559,629,957.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	429,901,696.02	429,901,696.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,754,896.44	-43,616,282.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	81,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,040,000.00	-29,360,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	103,558,704.40	147,301,254.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,457,395.78	-45,178,423.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,525,878.00	28,536,877.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,856,450.81	-9,555,163.73
39300	Биет бус хөрөнгө	16,174,828.34	16,055,898.38
39301	Програм хангамж	594,650.00	594,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-19,821.66	-138,751.62
39303	Бусад биет бус хөрөнгө	15,600,000.00	15,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	580,828,003.97	619,759,334.66
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	580,828,003.97	619,759,334.66
51	Засгийн газрын хувь оролцоо	580,828,003.97	619,759,334.66
51100	Засгийн газрын оруулсан капитал	720,601,014.08	0
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	720,601,014.08	0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0	720,601,014.08
51200	Хуримтлагдсан үр дүн	-167,698,290.73	-128,766,960.04
51210	Өмнөх үеийн үр дүн	-179,445,606.49	-167,698,290.73
51220	Тайлант үеийн үр дүн	11,747,315.76	38,931,330.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,925,280.62	27,925,280.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	580,828,003.97	619,759,334.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,494,770,219.66	4,131,269,929.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	109,638,085.66	268,415,954.04
120	Нийтлэг татварын бус орлого	109,638,085.66	268,415,954.04
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,527,000.00	48,518,349.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	106,111,085.66	219,897,605.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,385,132,134.00	3,862,853,975.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,163,701,400.00	3,804,075,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,163,701,400.00	3,804,075,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	221,430,734.00	58,778,075.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	2,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	206,430,734.00	53,478,075.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	2,500,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,465,934,737.30	4,092,338,598.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,465,934,737.30	4,092,338,598.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	652,105,990.26	738,222,756.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,021,648.11	315,043,830.14
210101	Үндсэн цалин	168,585,992.43	218,309,832.74
210102	Нэмэгдэл	75,444,678.87	52,071,520.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,596,000.00	29,397,000.00
210104	Урамшуулал	4,394,976.81	15,265,477.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,916,277.85	38,623,200.28
210201	Тэтгэврийн даатгал	23,286,938.61	26,757,143.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,592,816.50	3,147,899.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,064,173.15	2,518,319.35
210204	Ажилгүйдлийн даатгал	450,379.82	562,037.02
210205	Эрүүл мэндийн даатгал	4,521,969.77	5,637,801.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,490,547.00	54,463,990.97
210301	Гэрэл, цахилгаан	1,715,591.00	1,135,402.97
210302	Түлш, халаалт	47,859,328.00	51,177,131.00
210303	Цэвэр, бохир ус	1,915,628.00	2,151,457.00

2104	Хангамж, бараа материалын зардал	103,749,575.42	209,334,832.57
210401	Бичиг хэрэг	1,525,000.00	2,840,097.00
210402	Тээвэр, шатахуун	1,502,880.00	4,211,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	530,780.00	417,080.00
210404	Ном, хэвлэл	159,500.00	144,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	65,400.00	460,010.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,218,120.00	2,546,020.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	98,747,895.42	198,715,865.57
2105	Нормативт зардал	900,000.00	0
210502	Хоол, хүнс	900,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,478,000.00	833,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,500.00	0
210604	Урсгал засвар	2,452,500.00	833,050.00
2107	Томилолт, зочны зардал	108,000.00	8,648,900.00
210702	Дотоод албан томилолт	108,000.00	8,648,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,922,990.00	2,724,325.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,922,990.00	2,724,325.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	171,518,951.88	108,550,627.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	230,000.00	9,891,928.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	164,274,644.00	51,738,643.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,014,307.88	46,920,056.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,813,828,747.04	3,354,115,841.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,798,013,996.00	3,281,393,405.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	948,539,900.00	1,376,692,805.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	838,346,096.00	1,904,400,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,128,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,814,751.04	72,722,436.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,813,751.04	72,721,354.61
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,000.00	1,082.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	28,835,482.36	38,931,330.69
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17,088,166.60	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	17,088,166.60	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	11,747,315.76	38,931,330.69

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,385,132,134.00	3,862,853,975.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,385,132,134.00	3,862,853,975.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,163,701,400.00	3,804,075,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,163,701,400.00	3,804,075,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	221,430,734.00	58,778,075.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	2,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	206,430,734.00	53,478,075.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	2,500,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,385,132,134.00	3,848,493,275.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,385,132,134.00	3,848,493,275.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	571,303,386.96	494,377,433.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,021,648.11	315,043,830.14
210101	Үндсэн цалин	174,466,126.37	218,331,423.13
210102	Нэмэгдэл	69,564,544.93	52,071,520.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,596,000.00	29,397,000.00
210104	Урамшуулал	4,394,976.81	15,243,886.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,916,277.85	38,623,200.28
210201	Тэтгэврийн даатгал	23,286,938.61	26,757,143.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,592,816.50	3,147,899.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,064,173.15	2,518,319.35
210204	Ажилгүйдлийн даатгал	450,379.82	562,037.02
210205	Эрүүл мэндийн даатгал	4,521,969.77	5,637,801.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,490,547.00	54,463,990.97
210301	Гэрэл, цахилгаан	1,715,591.00	1,135,402.97
210302	Түлш, халаалт	47,859,328.00	51,177,131.00
210303	Цэвэр, бохир ус	1,915,628.00	2,151,457.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,726,560.00	12,104,767.00
210401	Бичиг хэрэг	3,385,000.00	2,349,697.00
210402	Тээвэр, шатахуун	2,292,880.00	6,181,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	530,780.00	417,080.00
210404	Ном, хэвлэл	187,900.00	144,300.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	65,400.00	460,010.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,264,600.00	2,552,220.00
2105	Нормативт зардал	900,000.00	0
210502	Хоол, хүнс	900,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,452,500.00	1,769,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,000,000.00	639,300.00
210604	Урсгал засвар	2,452,500.00	1,130,300.00
2107	Томилолт, зочны зардал	108,000.00	8,648,900.00
210702	Дотоод албан томилолт	108,000.00	8,648,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,072,190.00	2,724,325.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,072,190.00	2,724,325.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,615,664.00	60,998,820.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	230,000.00	9,290,177.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	164,385,664.00	51,708,643.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,813,828,747.04	3,354,115,841.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,798,013,996.00	3,281,393,405.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	948,539,900.00	1,376,692,805.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	838,346,096.00	1,904,400,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,128,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,814,751.04	72,722,436.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,813,751.04	72,721,354.61
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,000.00	1,082.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	14,360,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	14,360,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	14,360,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	14,360,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	14,360,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-14,360,700.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	720,601,014.08	35,783,703.66	-187,304,029.53	569,080,688.21
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	7,858,423.04	7,858,423.04
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	720,601,014.08	35,783,703.66	-179,445,606.49	576,939,111.25
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-7,858,423.04	0	-7,858,423.04
9	Тайлант үеийн үр дүн	0	0	11,747,315.76	11,747,315.76
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	720,601,014.08	27,925,280.62	-167,698,290.73	580,828,003.97
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	720,601,014.08	27,925,280.62	-167,698,290.73	580,828,003.97
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	720,601,014.08	27,925,280.62	-167,698,290.73	580,828,003.97
19	Тайлант үеийн үр дүн	0	0	38,931,330.69	38,931,330.69
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	720,601,014.08	27,925,280.62	-128,766,960.04	619,759,334.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,804,075,900.00	3,731,354,545.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,804,075,900.00	3,731,354,545.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	516,934,600.00	449,961,140.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	372,815,400.00	315,043,830.14
210101	Үндсэн цалин	227,574,800.00	218,331,423.13
210102	Нэмэгдэл	74,563,100.00	52,071,520.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,396,000.00	29,397,000.00
210104	Урамшуулал	37,281,500.00	15,243,886.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,601,900.00	38,623,200.28
210201	Тэтгэврийн даатгал	31,689,300.00	26,757,143.08
210202	Тэтгэмжийн даатгал	3,728,200.00	3,147,899.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,982,500.00	2,518,319.35
210204	Ажилгүйдлийн даатгал	745,600.00	562,037.02
210205	Эрүүл мэндийн даатгал	7,456,300.00	5,637,801.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,467,900.00	54,463,990.97
210301	Гэрэл, цахилгаан	5,914,700.00	1,135,402.97
210302	Түлш, халаалт	47,533,800.00	51,177,131.00
210303	Цэвэр, бохир ус	1,019,400.00	2,151,457.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,801,100.00	7,867,767.00
210401	Бичиг хэрэг	2,299,700.00	2,299,697.00
210402	Тээвэр, шатахуун	1,996,600.00	1,994,460.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	417,800.00	417,080.00
210404	Ном, хэвлэл	145,200.00	144,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,389,500.00	460,010.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,552,300.00	2,552,220.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,130,300.00	16,130,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	1,130,300.00	1,130,300.00
2107	Томилолт, зочны зардал	54,900.00	54,900.00
210702	Дотоод албан томилолт	54,900.00	54,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	973,700.00	956,325.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	973,700.00	956,325.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,089,400.00	16,820,827.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,294,200.00	9,290,177.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,795,200.00	7,530,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,287,141,300.00	3,281,393,405.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,287,141,300.00	3,281,393,405.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,378,895,000.00	1,376,692,805.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,907,918,300.00	1,904,400,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	300,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,804,075,900.00	3,731,354,545.39
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,804,075,900.00	3,731,354,545.39
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,804,075,900.00	3,731,354,545.39
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	45	45
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	21	21
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22	22
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	20	20
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	58,776,993.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	58,776,993.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	58,776,993.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	4,237,000.00
210401	Бичиг хэрэг	-	50,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	4,187,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	8,594,000.00
210702	Дотоод албан томилолт	-	8,594,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1,768,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,768,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	44,177,993.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	44,177,993.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1,082.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,082.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	58,778,075.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	58,778,075.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	53,478,075.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,500,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн, боловсрол, соёлын тогтвортой хөгжлийг хангаж, ЕБС, цэцэрлэг, соёл урлагийн болон бусад байгууллага, иргэдэд тасралтгүй, чанартай үйлчилгээг үзүүлэхэд оролцдог чиг үүрэг бүхий Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 27 сумын СӨБ-ын 54 бүлэг, ЕБС-ын 41 сургуулийн багш, сурагч, эцэг эхтэй шууд болон шууд бусаар хамтран ажиллаж үйл ажиллагаа явуулдаг байна.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 53 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 94%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь захиргааны нэгж, мэргэжил арга зүйн нэгж, үйлчилгээний нэгж гэсэн бүтэц, зохион байгуулалттай ба тайлант онд Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 14, үйлчилгээний ажилтан 10 бүгд 26 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Дотоод хяналт, шалгалтын комиссыг шинэчлэн батлах тухай" А/02 тушаал, 3 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллаж байна.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дотоод хяналт шалгалтын нэгж нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 16 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн 98,75 хувьтай хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын баг нь жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт санхүүгийн үйл ажиллагаанд хийж, алдаа зөрчил гарвал тухай бүрд нь засаж залруулах зөвлөмж өгч эргэн хяналт тавьж ажилладаг. Энэ онд шилэн дансанд хяналт шалгалт хийсэн байна.

Тус байгууллагад тайлант онд Төв аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2022 оны 11 дүгээр сард 2020 болон 2021 оны санхүүгийн тайлангийн баримтад хяналт шалгалт хийсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол шинжлэх ухааны яамны 2021 онд батлагдсан шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь 10 дэд бүлэгт бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна. НББ-ийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,931.3 мянган төгрөгөөр буюу 6,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	23,644.5	0	-23,644.5
Бараа материал	12,870.2	14,727.3	1,857.1
Үндсэн хөрөнгө	538,652.4	575,685.9	37,033.5
Нийт хөрөнгө	580,828.0	619,759.3	38,931.3
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	580,828.0	619,759.3	38,931.3

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	580,828.0	619,759.3	38,931.3
--	------------------	------------------	-----------------

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн дансанд орлого зарлагын хөдөлгөөн хийгдсэн болон хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалан өмнөх оны үзүүлэлтээс 37,033.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 619,759.3 мянган төгрөг болж 38,931.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 512,272.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 3,314,271.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж БШУЯ-ны 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 8/120 дугаар албан бичгийн хавсралтаар 2022 оны урсгал зардлын төсвийг 3,826,543.5 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Тайлант хугацаанд төсөвт тодотгол, өөрчлөлт ороогүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 3 /СӨБ, ЕБС, БШУ-ны бодлого, удирдлага/ хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,804,075.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 72,721.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,731,354.5 мянган төгрөг буюу 96,06 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 72,721.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71808 боловсрол шинжлэх ухааны бодлого, удирдлага 80101 үндсэн үйл ажиллагааны зардал	516,934.6	449,961.1	66,973.5	87,04
2	71802 ерөнхий боловсрол 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	3,287,141.3	3,281,393.4	5,747.9	99,06

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Боловсрол, шинжлэн ухааны газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 53,478.1 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2,800.0 мянган төгрөг, үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 2,500.0 мянган төгрөг, нийт 58,778.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар бичиг хэрэг, тээвэр шатахуунд 4,237.0 мянган төгрөг, дотоод албан томилолт 8,594.0 мянган төгрөг, бусад ажил үйлчилгээний зардалд 45,946.0 мянган төгрөг нийт 58,777.0 мянган төгрөг зарцуулж, 1.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801	2022.01.01-2022.12.31	СӨБ	Хөтөлбөр 99,7 %	878,041.0	875,779.1
2	71802	2022.01.01-2022.12.31	ЕБС	Хөтөлбөр 99,9 %	2,378,619.8	2,375,876.4
3	71808	2022.01.01-2022.12.31	БШУ-ны бодлого, удирдлага	Хөтөлбөр 87,6 %	547,415.1	479,699.0

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 72,721.4 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан 2022 оны нийт зарлага 3,826,543.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 57,398.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 43,048.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 39 орлогын, 172 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад алдаа, зөрчил илрээгүй тул асуудлын бүртгэл хөтлөөгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 167 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	48,511.7	2	48,511.7	100
Зөвлөмж	2	8,455.6	2	8,455.6	100
Нийт дүн	2	56,967.3	2	56,967.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.3 Албан шаардлага

1. Тус байгууллага тайлант онд 145.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, Зуунмод хот дотор явсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага тайлант онд шатахууны 2,760.0 мянган төгрөгийн талон авч нөөцөлсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

3. Тус байгууллага тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланд тусгаагүй сандал 16ш 3,165.0 мянган төгрөг, ширээ 6ш 2,046.0 мянган төгрөг, шүүгээ 5ш 3,300.0 мянган төгрөг, ус цэвэршүүлэгч 3ш 3,870.0 мянган төгрөг нийт 12,381.0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллага 145.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, Зуунмод хот дотор явсан байна.	1	145.0			1	145.0						
Шатахууны 2,760.0 мянган төгрөгийн талон авч нөөцөлсөн байна.	1	2,760.0			1	2,760.0						
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланд тусгаагүй 12.381.0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсан байна.	1	12,381.0			1	12,381.0						
Дүн	3	15,286.0			3	15,286						